

## "МОНИНЖБАР" ХК-ИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Бид 2019 онд "Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан баруун дүүргийн насос станц хүртэлх 8070 метр урттай Ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил"-аас 2500 метр шугам хоолойн угсралт сууринтуулалт, ЦУХ-ийн барилга угсралтын ажил-7-г болон 2000 метр далан үерийн байгууламжийн нөхөн сэргээлтийн ажлыг инженер техникийн 8 ажилтан, операторчин, жолооч -б, үндсэн 8, туслах 4, нийт 32 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэлээ.

Байгууллагын дотоодод заавал дагаж мөрдөх журмуудыг Хөдөлмөрийн тухай, Барилгын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн баримтуудыг үндэслэн шинээр боловсруулж батлан өдөр тутмын үйл ажиллагаандaa мөрдүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. "МОНИНЖБАР" ХК-ийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам
2. "МОНИНЖБАР" ХК-ийн инженер, техникийн ажилчдын дагаж мөрдөх журам
3. "МОНИНЖБАР" ХК-ийн нийт ажилчдын мөрдөх аюулгүй ажиллагааны журам
4. "МОНИНЖБАР" ХК-ийн хувийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны олголт ба ашиглалтын журам
5. "МОНИНЖБАР" ХК-ийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам
6. "МОНИНЖБАР" ХК-ийн дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм зэрэг болно.

Төслийн ажлын хүрээнд дээрх хууль эрх зүйн акт, дүрэм, журмыг үндэслэл болгон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн барилгын талбайн аюулгүй ажиллагааг ханган ажиллаж ирсэн бөгөөд "Амар даатгал" ХХК-тай 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан №ДГ-007-2019 дугаар даатгалын гэрээний үндсэн дээр хамтран ажилласан.

НЗДТГ-тай байгуулсан гэрээний хугацаа 2019.12.30-нд дуусах байсан тул төслийөс тавьсан шаардлагын дагуу HDPE шугам хоолойг БНХАУ-ын Шандонг мужийн Венюоаны технологийн үйлдвэрт захиалж, Хаан банкны зээлийн санхүүжилтээр нийт 6500 метр Ф600мм-ийн шугам хоолойг үйлдвэрлүүлэн УСУГ, НХОГ, УБГХХХОДХТ зэрэг төрийн байгууллагын хариуцсан мэргэжилтнүүдийг 3 удаа газар дээр нь томилолтоор ажиллуулж, олон улсын хөндлөнгийн SGS шинжилгээнд 4 удаа хамруулан баталгаажуулж, Эрээн боомтоор тээвэрлэн авчирсан.

Төслийөс шугам хоолойгоо 100 хувь авчирсан тохиолдолд материалын зардлаар санхүүжилтийг өгөх боломжтой гэсний дагуу зөвхөн шугам хоолойн худалдан авалтанд зориулж Хаан банкнаас 2 444.4 сая /хоёр тэрбум дөрвөн зуун дөчин дөрвөн сая дөрвөн зуун мянган/ төгрөгийн зээл авснаас 2019 оны жилийн эцсийн байдлаар энэ зээлийн үлдэгдэл 544 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь төслийн хамтрагч түншлэлийн Н Эй Би ХХК өнгөрсөн онд 1 метр ч шугамын ажлын гүйцэтгэл хийгээгүй, ажлаа эхлүүлээгүйтэй холбоотой.

Мөн энэ ажлыг авахын тулд 2017 оны 8 дугаар сард тендерт түншлэлээр оролцохдоо хамгийн доод үнэ нь сайн үнэ буюу ажлын тоо хэмжээндээ хүрэлцэхгүй төсөв зохиосон, барилгын материалын үнэ ханшийн өсөлт, техник технологийн шинэлэг шийдлүүдтэй холбоотойгоор ажил гүйцэтгэх шаардлага өөрчлөгдөж байгаа зэрэг нь өнөөдрийн санхүүгийн алдагдалд нөлөөлж байна.

Талбайн ажлын явцад хүндрэл бэрхшээлүүд гарч байсан хэдий ч цаг алдахгүйгээр хариуцсан 2 дүүргийн 30 гаруй байгууллагуудтай хамтран ажиллаж газар дээр нь шуурхай зохион байгуулж

ирлээ. Гэвч төрийн байгууллагын шийдвэр, зөвшөөрөл гарахгүйгээс талбайн ажлын хувьд сүл зогсох, цаг алдах явдал байсаар байна, ялангуяа трассын дагуух газар чөлөөлөлтийн ажил хугацаандаа хийгддэггүй, автозамын зөвшөөрлийг олгодоггүй зэрэг биднээс үл хамаарах шалтгаанаар ажил саатах тохиолдол байна.

Харин сайн мэдээ нь Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн 2019 оны шугам хоолойн угсралт сууринуултыг гүйцэтгэсэн компаниудаас манай компани хамгийн олон метр буюу 2500 метрийг угсарч, өөрийн хариуцсан трассын 70 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь төслийн хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт болж үнэлэгдсэн.

Компанийн хувьд өөрийн мөнгөн хуримтлалгүй төрөөс авч гүйцэтгэж буй тендерийн ажлыг банк санхүүгийн байгууллагын зээлийн эх үүсвэрээр шийдэж ирснээс улбаалан гүйцэтгэж буй ажлын ашиг нь зээлийн хүүгийн төлбөрт зориулагдаж, гэрээний хугацаа сунах тусам алдагдал өсч байна.

Энэ байдал 2020 онд ч үргэлжилж алдагдалтай ажиллахаар байгаа нь 2020 оны төсвийн төлөвлөлтөөс харагдаж байна.

Өнгөрсөн 2019.07.04-ны өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн компанийн хуучин конторын барилгыг 9 дүгээр сард буулгаж, САН ХХК-тай хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж барилга угсралтын ажил эхэлсэн.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд хүсэлт гаргаж мэргэжлийн болон үйлдвэр дээрх сургалтын зөвшөөрлийг авсан нь өөрсдийн ажилчдаа болон бусдад мэргэшүүлэх сургалт явуулах нөхцөл бүрдлээ.

Цаашид төслийн ажлыг үргэлжлүүлэн хугацаандаа, чанартай гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгөх зорилготой ажиллаж байна.